

Удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2,30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.5, 30.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын бэлэн байдлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамжийг 2018 оны дугаар сарын өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

3. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны бэлэн байдлын удирдамжид заасан хүн нэг бүрийн хээрийн үүргэвч, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хангалт, заагдсан нөөцүүдийг үе шаттайгаар бэлтгэж, хангах арга хэмжээг зохион байгуулахыг Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга, дэд хурандаа Я.Гантөмөр, Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

4. Энэ удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (бригадын генерал Г.Ариунбуян)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ

ТАНИЛЦУУЛГА

2018.09.19

Гамшгаас хамгаалах тухай хууль бусад холбогдох хууль, дүрэм, журмыг үндэслэн Онцгой байдлын байгууллагын “Бэлэн байдлын удирдамж”-ийн төслийг 11 зүйл, 56 хэсэгтэйгээр шинээр боловсрууллаа.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, үйлдвэр, технологийн хөгжил, хүний буруутай үйл ажиллагааны улмаас цаг агаарын аюулт үзэгдэл, геологи, биологийн гаралтай аюул ослын төрөл, тоо, давтамж өсөн нэмэгдэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, мал аж ахуй, байгаль экологи, улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулж байна.

Цаг агаар, геологи, биологийн гаралтай аюулт үзэгдэл осол /цацраг, хими, биологи, үйлдвэрлэлийн осол, тэсэрч дэлбэрэх бодис, үер, объектын болон ой хээрийн түймэр, газар хөдлөлт/ нь гэнэт, хурдан хугацаанд болж ихээхэн хэмжээний хохирол учруулж байна.

Иимд болзошгүй гамшиг осол, аюулт үзэгдэл тохиолдсон үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах аврах, хор уршгийг арилгахад Онцгой байдлын байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах шаардлагатай байгаа тул Онцгой байдлын байгууллагын “Бэлэн байдлын удирдамж”-ийг боловсруулсан болно.

Онцгой байдлын байгууллагын “Бэлэн байдлын удирдамж” батлагдсанаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, улсын нөөцийн анги, салбар, Үндэсний аврах бригад болон бүтцийн нэгжүүд гамшиг, осол, аюулт үзэгдэл болсон үед алба хаагчдын хувийн болон албаны бэлтгэл, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэл, ар талын нөөц хангалтыг үе шаттайгаар хангаж гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх чадавхи дээшилж бэлтгэл бэлэн байдал сайжирна.

Онцгой байдлын байгууллагын “Бэлэн байдлын удирдамж”-д гамшгаас хамгаалах бэлэн байдал, бэлэн байдлын зарчим, тодорхойлох үр дүн, Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх газар, хэлтэс, албан тушаалтныг зааж өгсөн.

Мөн гамшгаас хамгаалах бэлэн байдлын түвшинг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, удирдлагын үйл ажиллагаа, бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдал, гамшгийн үеийн харилцан ажиллагаа, холбоо, зарлан мэдээлэл, аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц бүрдүүлэлт гэсэн 7 үзүүлэлтийг тус бүрээр задлан боловсруулсан.

Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед үүрэг гүйцэтгэх эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хоол, хүнс, шатах тослох материалын хангалт, нөөц, хүн нэг бүрийн хээрийн үүргэвчний иж бүрдэл, шуурхай штаб, хөдөлгөөнт болон суурин удирдлагын байранд шаардлагатай тоног төхөөрөмж, эд материал, хэрэгслийг нэр төрлөөр нь зааж өгсөн.

Удирдамжид Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн бэлэн байдлын хангах шалгүүр үзүүлэлт, үзүүлэлтийн дагуу бэлэн байдлын түвшинг шалгаж, үнэлэх зохицуулалтыг тусгасан.

Бэлэн байдлын удирдамжийг боловсруулахад дараах хууль, дүрэм, журам, зааврыг судалсан.

Үүнд: Гамшгаас хамгаалах тухай хууль, Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, ОХУ-ын “Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг зохион байгуулах үеийн аврах ангийн тактикийн үйл ажиллагаа”, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах байгууллагын бэлэн байдлын удирдамж зэргийг судалсан болно.

Удирдамжийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлах юм.

Иймд “Бэлэн байдлын удирдамж”-ийн төслийг хэлэлцэж холбогдох шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БЭЛЭН БАЙДЛЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах бэлэн байдал гэж гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулах хүн, хүч техник хэрэгслийн бэлэн байдлын чадавхыг хэлнэ.

1.2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан өдөр тутмын бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал гэсэн 3 зэрэгтэй байна.

1.3. Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зарчмуудад тулгуурлана:

1.3.1. гамшгийн нөхцөл байдалд авах хариу арга хэмжээг урьдчилан төлөвлөсөн байх;

1.3.2. бэлтгэгдэж, дадлагажсан байх;

1.3.3. гамшгийн нөхцөл байдалд нийцсэн байх;

1.3.4. шуурхай байх;

1.3.5. тасралтгүй байх;

1.4. Онцгой байдлын байгууллагыг гамшгийн нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлаас өндөржүүлсэн бэлэн байдалд бүрэн болон хэсэгчлэн шилжүүлнэ.

1.6. Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах үр дүнгээр хангагдана.

1.6.1. хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдал хангагдсан байх;

1.6.2. тогтвортой, тасралтгүй удирдлагатай байх;

1.6.3. бэлэн байдлыг хангах түвшинтэй байх;

1.6.4. онцгой байдлын байгууллага гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод шуурхай шилжин байрлаж хор уршгийг богино хугацаанд арилгасан байх;

1.6.5. улсын онцгой комисс, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги бусад байгууллагатай харилцан ажиллагааг тасралтгүй зохион байгуулсан байх;

Хоёр. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын түвшин

2.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын түвшин нь:

2.1.1. хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны

2.1.2. удирдлагын үйл ажиллагааны

2.1.3. бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлын

2.1.4. гамшгийн үед ашиглагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлын

2.1.5. харилцан ажиллагааны

2.1.6. мэдээлэл, технологийн

2.1.7. нөөц бүрдүүлэлтийн гэсэн чиглэлээр тодорхойлогдоно.

2.2. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны түвшин нь алба хаагчийн болон байгууллагын аюулгүй байдлын арга хэмжээнээс бүрдэнэ.

2.2.1. алба хаагчийн аюулгүй байдлын түвшин нь:

- Аврах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэх;

- Гамшгийн үед өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хамгаалах талаар зохих мэдлэгтэй байх;
- Бие бялдар сэтгэлзүйн бэлтгэлтэй байх;
- Газар орон, улиралын нөхцөл байдалд зохицон үүрэг гүйцэтгэх чадвартай байх;
- Мэдээ мэдээлэл хүлээн авах, дамжуулах, зарлан мэдээлэх чадвартай байх;
- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааврыг хэрэгжүүлдэг байх;
- Өөрт оногдсон техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах, дадлага, чадварыг эзэмшсэн байх;

2.2.2.байгууллагын аюулгүй байдлын түвшин нь:

- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах шуурхай штабын бүтэцтэй байх;
- Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, бие бүрэлдэхүүнийгбэлэн байдлаа хангах ажиллагаандсургаж дадлагажуулсан, сургалтыг тасралтгүй явуулсан байх;
- Бүх төрлийн хангалтын нөөцийг бүрдүүлэн ашиглах, хадгалах, тээвэрлэх нөхцөлөөр хангагдсан байх;
- Нэгдсэн удирдлагад холбогдсон зарлан мэдээллийн дохио дамжуулах, хүлээн авахсистемтэй байх,
- Эрэн хайх, аврах ажиллагааг шөнийн цагт явуулах гэрэлтүүлгийн систем, хүйтний улиралд гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангагдсан байх;
- Шуурхай штабын хөдөлгөөнт болон суурин байруудыг дэлгэх бэлтгэлтэй байх;
- Бүх шатны томилгоот бүлгийг холбогдох хууль тогтоомжд нийцүүлэн томилох, зориулалтын техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан байх;
- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж бие бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулсан байх;
- Онцгой байдлын байгууллага гамшиг, аюулт үзэгдэл, ослын тухаймэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах боломжоор хангагдсан байх;

2.3.Удирдлагын үйл ажиллагааны бэлэн байдлын түвшиннь:

2.3.1.гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдалд аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдах мэдлэг, эзэмшсэн, хууль эрх зүйн хүрээнд шийдвэр гаргах чадвартай байх;

2.3.2.өөрийн болон нөөц, бусад хүч хэрэгслийг үнэлэх, хүч хэрэгслийг тооцох, цагийн тооцоог гаргах, аврах ажиллагаанд оруулах чадвартай байх;

2.3.3.мэдээ мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байх;

2.3.4.бүх төрлийн хангалтыг зохион байгуулсан байх;

2.4.Бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлын түвшиннь:

2.4.1.бэлтгэл, бэлэн байдлыг хангахсургалт, дадлагадхамрагдсан байх;

2.4.2.бие бялдрын шалгуур үзүүлэлтийн түвшингхангасан байх;

2.4.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед алба хаагч нь холбогдох төлөвлөгөөнд томилгоожсон,төлөвлөгөөнд заагдсан үүргийг хэрэгжүүлж мэддэг байх;

2.4.4.гамшгийн үед ашиглагдах өөрт оногдсон техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах дадлага, чадварыг эзэмшсэн дадлагажсан байх;

2.4.5.газар орон, улирлын байдалд зохицон үүрэг гүйцэтгэх чадвартай байх;

2.4.6.сэтгэл зүйн бэлтгэл, бэлэн байдал хангагдсан байх;

2.5. Гамшгийн үед ашиглагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлын түвшиннь:

2.5.1.техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалт,хамгаалалтыг холбогдох дүрэм, журам, зааврын дагуу зохионбайгуулсан байх;

2.5.2.техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нарийвчилсанбүртгэл, судалгаа, тооцоотой, нөхөн хангалтаар бүрэн хангасан байх;

2.5.3.техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийж, үүрэг гүйцэтгэх боломж, бэлэн байдлыг хангасан байх;

2.5.4.алба хаагчид хариуцсан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээашиглах чадварыг эзэмшүүлсэн байх;

2.6.Харилцан ажиллагааны бэлэн байдлын түвшиннь:

2.6.1.гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл(улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, онцгой комисс)-ийн харилцан ажиллагааг журмаар зохион байгуулж, дадлагажсан байх;

2.6.2.онцгой байдлын байгууллага нь дайчилгаа явуулах бүтэцтэй, нүүлгэн шилжүүлэх төлөвлөлттэй байх;

2.6.3.дайчилгааны хүч хэрэгсэл, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгааг нарийвчлан тогтоосон судалгаатай байх;

2.6.4.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн алба хаагч нь холбоо зохион байгуулах чадварыг эзэмшсэн, холбогдох төлөвлөгөөнд томилгоожсонбайх;

2.6.5.үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулсан байх;

2.6.6.дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч байгууллагуудтай харилцан ажиллах журам, төлөвлөгөөг боловсруулсан, тодотгосон байх;

2.6.7.гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах дадлага, сургууль явуулж хэвшсэн байх;

2.7.Мэдээлэл, технологийн бэлэн байдлын түвшиннь:

2.7.1.онцгой байдлын байгууллага гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах техник хэрэгслээр хангагдсан байх;

2.7.2.алба хаагч нэг бүр нь холбоо, зарлан мэдээллийн дэвшилтэт техник хэрэгслээр хангагдсан байх;

2.7.3.гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах дэвшилтэт техник хэрэгслийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх;

2.7.4.мэдээлэл, технологийн техник хэрэгслийн найдвартай ажиллагаа, гамшгийн мэдээ, мэдээллийнүнэн бодит, тасралтгүй байдлыг хангасан байх;

2.8. Нөөцийнбэлэнбайдлын түвшиннь:

2.8.1.Онцгой байдлын ерөнхий газар нь Аврах тусгай анги, Уул, уурхайн аврах анги, Хангалт үйлчилгээний анги, төв, орон нутгийн Онцгой байдлын газар

нь эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн хүний нөөцийг орон тоогоор нөхөн хангах судалгаатайбайх;

2.8.2.голомтод үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлэгтшаардлагатай хоол, хүнс, дулаан хувцас, шатах тослох материал болон бусад нөөцийгнэгдүгээр хавсралтад заасны дагуу бүрдүүлсэн байх;

2.8.3.холбогдох албан тушаалтнууд нөөц хүч, хэрэгслийн бүртгэл, судалгааг нарийн хөтөлсөн байх;

2.8.4.гамшгийн үед ашиглагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байх;

Гурав. Гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдал

3.1. Гамшгаас хамгаалахөдөр тутмын бэлэн байдал гэдэг нь Онцгой байдлын байгууллагагамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод шуурхай шилжин байрлах, мэргэжлийн байгууллагатай хамтран хор уршгийг арилгах,бэлэн байдлындараагийн зэрэгт шилжихчадварыг хангасан арга хэмжээг хэлнэ.

3.2. Гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлын үед дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;

3.2.2.зарлан мэдээллийн дохиогоор ажиллахчадварт бие бүрэлдэхүүнийг сургаж, дадлагажуулах;

3.2.3.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах сургалт, дадлагыг тасралтгүй явуулах;

3.2.4.шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилгоожуулан дадлагажуулах, ажиллах журмыг боловсруулах;

3.2.5.хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд бие бүрэлдэхүүнийг сургах;

3.2.6.удирдах бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зохион байгуулах;

3.2.7.эрэн хайх, аврах ажиллагаанд ашиглах эрэлч нохойг сургаж, дадлагажуулан, шаардлагатай тоног хэрэгслийг бүрдүүлэх;

3.2.8.харилцан ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх, төлөвлөлтийг боловсронгуй болгох, төлөвлөгөөг тодотгох;

3.2.9.гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, мэдээллийг хүлээн авах техник тоног төхөөрөмжийг бүрдүүлэх;

3.2.10.цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох дадлага, чадвартай мэргэжилтнийг сургаж, бэлтгэх;

3.2.11.дэвшилтэт мэдээлэл, технологийн техник, хэрэгслийг судлах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

Дөрөв: Өндөржүүлсэн бэлэн байдал

4.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал гэдэг нь Онцгой байдлын байгууллагагамшгийн голомтод шуурхай шилжин байрлаж, эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгслийг дайчлах, мэргэжлийн байгууллагатай хамтран хор уршгийг арилгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх чадварыг хэлнэ.

4.2. Гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай

хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.12 дахь заалтыгүндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжинэ.

4.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга /захирагч/ өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргана.

4.4.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеддараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Ц+00.00-00.05 цаг хүртэл

4.4.1."Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.5 дахь хэсэгт заасны дагуу "Яаралтай цуглар" "улбар шар" кодоор бие бүрэлдэхүүнд зарлан мэдээллийн дохио дамжуулна.

4.4.2. Онцгой байдлын байгууллага хоёрдугаар хавсралтад заасны дагуу бэлэн болно.

Ц+00.05-01.30 цаг хүртэл

4.4.3.зарлан мэдээллийг авсан алба хаагчмөн журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсэгт заасны дагуу цуглана.

4.4.4.хөдөлгөөнт болон суурин шуурхай удирдлагын байрыг хариуцсан нэгжгуравдугаар хавсралтад заасан иж бүрдэлтэйгээр дэлгэж бэлэн болгоно.

4.4.5.шуурхайудирдлагын штабын бүрэлдэхүүндөрөвдүгээр хавсралтад заасан бүтэц үүргийн дагуу ажиллана.

4.4.6.бүх шатны газар, хэлтэс,эрэн хайх, аврах ангийн холбооны зангилгаанд байнгынжижүүлэлтийг томилно.

Ц+01.30-02.30 цаг хүртэл

4.4.7.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.4.8.гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг цуглуулах, үнэлэх, тушаал, захирамжгаргах;

4.4.9.гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл (улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, онцгой комисс)-ийн харилцан ажиллагааг зохион байгуулах;

4.4.10.эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах шийдвэр гаргах;

4.4.11.харилцан ажиллах журмыг тодотгох, үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дэс дарааллыг тогтоон аврах ажиллагаанд оролцуулах;

4.4.12.шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

Ц+02.30-03.30 цаг хүртэл

4.4.13.гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардагдах нөөцийг хуваарилах;

4.4.14.хүмүүнлэгийн тусламжийг бүх шатанд зохион байгуулах;

4.4.15.бэлэн байдлын дараагийн зэрэгт шилжих бэлтгэлийг хангах;

Тав. Бүх нийтийн бэлэн байдал

5.1.Гамшгаас хамгаалахбүх нийтийн бэлэн байдал гэдэг нь Онцгой байдлын байгууллагатомоохон хэмжээний гамшгийн үед шуурхай ажиллагааг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгслийг дайчлах, мэргэжлийн байгууллагатай хамтран хор уршгийг арилгах,

хойшлуулшгүй сэргээн босгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх чадварыг хэлнэ

5.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид үүссэн голомтын бүсэд эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 зүйлийн 11.3.3 дахь заалт, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газрын тогтоол, шийдвэрийн "Бүх нийтийн бэлэн байдал"-ын зэрэгт шилжинэ.

5.3. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Онцгой байдлын байгууллагадараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Ц+00.00-00.05 цаг хүртэл

5.3.1. Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журмын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.6 дахь заалтын "Яаралтай цуглар" "улаан" кодоор бие бүрэлдэхүүнд зарлан мэдээллийн дохио дамжуулна.

Ц+00.05-01.30 цаг хүртэл

5.3.2. зарлан мэдээллийг авсан алба хаагч мөн журмын 2 дугаар зүйлийн 2.11 дэх заалтад заасны дагууцугларна.

5.3.3. шуурхай удирдлагын хөдөлгөөнт байрыг хариуцсан нэгж дэлгэж бэлтгэнэ.

5.3.4. бүх шатны газар, хэлтэс, эрэн хайх, аврах ангийн холбооны зангилгаанд байнгын жижүүрлэлтийг томилох;

Ц+01.30-02.30 цаг хүртэл

5.3.5. гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, мэдээллээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Улсын онцгой комиссыг хангах;

5.3.6. төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг гамшгаас хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах ажлыг зохион байгуулах;

5.3.7. гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг дайчлах;

5.3.8. хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх;

5.3.9. гамшгаас хамгаалах хүч хэрэгсэлд дэс дараалал тогтоон аврах ажиллагаанд оролцуулах;

Ц+02.30-03.30 цаг хүртэл

5.3.10. гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;

5.3.11. хүмүүнлэгийн тусламжийг бүх шатанд зохион байгуулах;

Зургаа. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээг

Хэрэгжүүлэх газар, тушаалтан

6.1. Гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан нэгж

6.1.1. гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гамшгийн үед харилцан ажиллах төлөвлөгөө, дайчилгааны төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох;

6.1.2. болзошгүй гамшиг, ослын үед ажиллах төлөвлөлтүүдийг урьдчилан боловсруулах, томилгоо хийх,

6.1.3. Бэлэн байдлыг хангах арга хэмжээний хүрээнд команд штабын дадлага, сургууль явуулах;

6.1.3.Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бэлтгэл, бэлэн байдлыг тавдугаар хавсралтад заасны дагуу шалгаж үнэлэх үзүүлэлтээр жилд 1-ээс доошгүй удаа шалгаж, гарсан зөрчлийг арилгуулах;

6.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгж

6.2.1.улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, онцгой комиссын бүрэлдэхүүн, алба хаагчдад гамшгийн үед ажиллах сургалт, дадлагыг бодит нөхцөл байдалд ойртуулж зохион байгуулах, дадлагажуулах;

6.2.2.сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх;

6.2.3.үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтарсан сургалтад оролцох, туршлага солилцох;

6.2.4.алба хаагчийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

6.3.Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан нэгж

6.3.1.бүх төрлийн холбоог тогтвортой, тасралтгүй зохион байгуулах;

6.3.2.мэдээллийн сүлжээний бэлэн байдал, нууцлалт, аюулгүй байдлыг хангах;

6.3.3.холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, програм хангамжийн ашиглалт, хангалт, засвар үйлчилгээг зохион байгуулах;

6.3.4.холбооны багаж хэрэгслийн шаардлагатай нөөц бүрдүүлэх, нөхөн хангалт хийхэд бэлэн байх;

6.3.5.холбооны техник, хэрэгслийг ашиглах талаар бие бүрэлдэхүүнд сургалт, дадлага явуулах;

6.4. Эмч, сэтгэл зүйч

6.4.1.алба хаагчийн гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах;

6.4.2.сэтгэл зүйг идэвхжүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах;

6.4.3.гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчийг судлаж, саналаа танилцуулах;

6.4.4.эмнэлгийн тусламжийг төлөвлөж, хэрэгжүүлэх;

6.4.5.бие бүрэлдэхүүнд эмнэлгийн анхны тусламжийн мэдлэг олгох;

6.4.6.бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх;

6.4.7.эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх;

6.4.8.эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох, боох материал, оношлогоо, эмчилгээ, шинжилгээний багаж тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх;

6.5. Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж

6.5.1.Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хүн нэг бүрийн хангалтыг “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад заасны дагуу зохион байгуулах, нөхөн хангах;

6.5.2.гамшгийн үед ашиглагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нөхөн хангалтыг зохион байгуулах, хадгалалт, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

6.5.3.автомашин бусад техникийн хангалтыг зохион байгуулж, хадгалалт,

хамгаалалт, ашиглалт, эзэмшилт, бүртгэл тооцоонд хяналт тавих;

6.5.4.бүх төрлийн тээвэрлэлтийг зохион байгуулах;

6.5.5.тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах, журам боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

6.5.6.марш үйлдэх үеийн тооцоог гаргаж, маршийн захирамж боловсруулах;

6.5.7.автомашин техникийн засвар, үйлчилгээг тогтоосон хугацаанд хийх, тэдгээрийн ашиглалт хяналт тавих;

6.5.8.жолооч механикч нарын ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлагыг зохион байгуулах;

6.5.9.техникийн бэлэн байдлыг хангах;

6.5.10.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээний төсөв боловсруулахад шаардлагатай үндэслэл, тооцоо судалгааг бэлтгэх;

6.5.11.батлагдсан төсвийг Онцгой байдлын байгууллагын онцлог, гамшиг, аюулт үзэгдэл, осол, байгаль цаг уурын нөхцөл байдалтай уялдуулж оновчтой, уян хатан хуваарилж, зарцуулах;

6.5.12.болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хэрэглэх бэлэн мөнгөний нөөцийг бүрдүүлсэн байх;

6.6.Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн асуудал хариуцсан нэгж,

6.6.1.гамшгийн үед ашиглагдах хүнс, хуурай хэрэглэлийг бэлтгэх, татан авах, тээвэрлэх, хадгалах, хуваарилан хүргэх ажлыг зохион байгуулж, хүнсний нөөцийг цаг тухайд нь сэлгэж шинэчлэх;

6.6.2.бие бүрэлдэхүүнийг эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан хүнсээр хангах;

6.6.3.хөдөлгөөнт болон суурин удирдлагын байрыг “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх залтад заасны дагуу бэлтгэх;

6.6.4.бие даан үүрэг гүйцэтгэх анги, салбар, бүлгийн өвөл, зуны хөдөлгөөнт байрыг бэлтгэх, хангах, бэлэн байлгах;

6.6.5.шаардлагатай нөөцийг нөхөн хангах талаар холбогдох байгууллагатай гэрээ байгуулсан байх;

6.7. Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны асуудал хариуцсан нэгж

6.7.1.бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

6.7.2.бэлэн байдлын зэргүүдийн зорилгод тохирсон журам тогтоох;

6.7.3.онцгой байдлын байгууллага, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албатай харилцан ажиллах журмыг тогтоох;

6.7.4.Олон улсын хүмүүнлэг тусламжийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах.

Долоо.Бусад

7.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага автомашин, техник хэрэгслийн шаардлагатай сэлбэг, хэрэгслийн болон шаардлага гарсан үед хэрэглэх бэлэн мөнгөний (1 саяс дээш төгрөг)-ийн нөөцтэй байна.

7.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд халдашгүй нөөцийг шаардлагатай үед ашиглах зорилгоор холбогдох журам, стандартын дагуу

хадгалж, тогтоосон хугацаанд сэлгэж, шинэчлэх бөгөөд ахлах дарга зохион байгуулна.

7.3. Халдашгүй нөөцийг зарцуулах шаардлага гарсан тохиолдолд ахлах даргад илтгэж, зөвхөн түүний шийдвэрээр зарцуулна.

7.4. Зарцуулсан нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

Материал хэрэгслийн нөөц

Материал хэрэгслийн нөөцийг зориулалтаар нь:

- Урсгал хангалтын нөөц
- Халдашгүй нөөц гэж ангилна.

Үндэсний аврах бригад, төв, орон нутгийн Эрэн хайх, аврах анги, салбарт

Д/д	Нөөцийн нэр	Нөөцийн ангилал	Тоо/хэмжээ
1	Хүнс	Халдашгүй нөөц	10 хоног/өгөхөөр
		Урсгал хангалтын нөөц	30 хоног/өгөхөөр
2	Шатахуун	Халдашгүй нөөц	1 цэнэг
		Урсгал хангалтын нөөц	2 цэнэг
3	Дулаан хувцас	Халдашгүй нөөц	60% б/б
		Урсгал хангалтын нөөц	80% б/б
4	Холбоо	Хэт богино долгионы радиостанц	6ш
		Богино долгионы радиостанц	6ш
		Хэт богино долгионы гар станц	80ш
5	Түлш	Халдашгүй нөөц	20 хоног

Материал хэрэгслийн нөөцийг дор дурдсанаар тодорхойлно. Үүнд:

- Материал хэрэгслийн нөөц гэж төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын агуулахад орон тоо, табелийн дагуу тогтоосон тоо хэмжээгээр хадгалагдаж байгаа гамшгийн үед ашиглагдах, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техникийн засвар, шатахуун, хүнс, хувцас, эмнэлэг, инженер, орон сууцны материал хэрэгслийн нөөцийг хэлнэ.

"Урсгал хангалтын нөөц" гэдэг нь байнгын бэлэн байдлын үед үүрэг гүйцэтгэх, сургалт, дадлага, өдөр тутмын үйл ажиллагааг хангах зориулалт бүхий материал хэрэгслийн нөөцийг хэлнэ.

"Халдашгүй нөөц" гэдэг нь гамшиг, аюулт үзэгдэл, осол үүссэн үед зөвхөн ахлах даргын шийдвэрээр зарцуулах материал хэрэгслийн нөөцийг хэлнэ. Нөөцүүдийг цувраажилтын дагуу тусгайлан бүрдүүлж, жагсаалтын дагуу төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын агуулахад хадгална.

- нөөцөд хадгалах материал хэрэгслийн хэмжээг санхүү, хангалт, хөрөнгө оруулалт хариуцсан нэгж тооцно. Хангалтын тооцооны нэгжийг материал хэрэгслийн нэр, төрлөөс шалтгаалж дараах байдлаар мөрдөнө. Үүнд:

а. Шатахууны цэнэг:

- Дугуйт техникт шатахууны үндсэн нормоор 500 км явахад зарцуулах
- Агрегатад 50 мото/цаг ажиллахад зарцуулах
- Хүнд машин механизмын (бульдозерь, кран, экскаватор гэх мэт) үндсэн ба туслах шатахууны савыг бүрэн цэнэглэх шатахууны хэмжээгээр тус тус тодорхойлно.

б. Хүнсний хоногийн өгөхөөр: Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан хүнсний нормын дагуу цэргийн алба хаагчдад нэг хоногт зарцуулах хүнсний материал хэрэгслийн хэмжээгээр тодорхойлогдоно.

в. Хувцасны иж бүрдэл: Онцгой байдлын байгууллагын алба хаагчдад тогтоосон нормын дагуу нэг удаа олгох хувцас хэрэглэлийн хэмжээгээр

тодорхойлогдоно.

г. Түлшний хоногийн хэрэгцээ: Анги, салбаруудын орон тооны хоол боловсруулах болон дулааны зориулалтаар ашиглах нийт тоног төхөөрөмж, табель хэрэгслийн нэг хоногт зарцуулах хатуу болон шингэн түлшээр тодорхойлогдоно.

д. Эмнэлгийн иж бүрдэл: Бие бүрэлдэхүүнд болон нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зориулалтаар бэлтгэсэн эм, ороох боох материалын багцаар тодорхойлогдоно. Үзүүлэх тусламжийн шатлалаас хамаарч багцын иж бүрдэл, нэр төрлийн хувьд ялгаатай байна.

- аврах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл: гамшгийн төрөл тус бүрд ашиглагдах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүлэг, салбар, ангид тогтоож өгснөөр тодорхойлогдоно.
- техникийн засварын иж нь: техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг сэргээн босгох зорилгоор урсгал болон дунд засвар хийхэд шаардлагатай засварын ижээс бүрдэнэ.

а. Урсгал засварын иж гэдэг нь техникт урсгал засвар хийх сэлбэгийг үндсэн агрегат оруулахгүйгээр бүрдүүлснээр тодорхойлогдоно.

б. Дунд засварын иж гэдэг нь техникт урсгал засвар хийх сэлбэгийг үндсэн агрегаттайгаар бүрдүүлснээр тодорхойлогдоно.

- материал хэрэгслийн нөөцийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталгаажуулж мөрдөнө.
- Алба хаагч, бүлэг, шуурхай штабт байх иж бүрдлүүдийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу бүрдүүлнэ.

Онцгой байдлын байгууллагын бэлэн болох хугацаа

д/д	Нэгжийн нэр	Бэлэн болгох хугацаа /цаг, минутаар/			
		Зун		Өвөл	
		Өдөр	Шөнө	Өдөр	Шөнө
1	Онцгой байдлын ерөнхий газар “Шуурхай штаб”	Ц+01.40 цаг	Ц+01.10 цаг	Ц+01.50 цаг	Ц+01.30 цаг
2	Аврах тусгай анги	Ц+01.20 цаг	Ц+00.50 цаг	Ц+01.30 цаг	Ц+01.10 цаг
3	Уул, уурхайн аврах анги				
4	Хангалт үйлчилгээний анги				
5	Төв, орон нутгийн Эрэн хайх, аврах анги, салбар, бүлэг	Ц+00.40 цаг		Ц+01.00 цаг	

Тайлбар: Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн дээрх хугацаанд 3 хоногийн хоол, хүнс, улирлын хувцас, гамшгийн үед ашиглагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, авто машин шатахууны цэнэгтэйгээр гамшгийн голомтод бие даан үүрэг гүйцэтгэхээр бэлэн болно.

